Зураг 2.3 Хан-Уул дүүргийн Зэвсэгт хүчний 310-р ангийн мод үржүүлгийн сургалтын төв, тэрбум мод төслийн 1-р байршилд 10 ш Монос мод тарьсан байдал.

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших
 “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны **2022**
 менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ХАВСРАЛТ 4. ОСОЛ, ЭРСДЭЛИЙН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ

УУРЫН БА ХАЛААЛТЫН ЗУУХ, ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
 АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА
 2021/04/02-Хувилбар 1





C2 (дотоод хэрэгцээнд)

БАТЛАВ: АГАР ЭНЕРЖИ ХХК
 ҮЙЛДВЭР ХАРИУЦСАН МЕНЕЖЕР:  Д.ШИЖИРБАТ

Баримт бичгийн төрөл:	Заавар
Үйлчлэх хүрээ:	Уурын ба халаалтын зуух болон хийн үйлдвэр
Хэрэгжүүлэх нэгж, ажиллагчид:	Үйлдвэрийн ажиллагчид
Харэгжилтэд хяналт тавих:	Ахлах инженер
Нууцын зэрэг:	C2 (дотоод хэрэгцээнд)
Хүчинтэй хугацаа:	Хүчингүй болгох хүртэл
Хуудасны тоо:	5
Анх баталсан огноо	2021.04.02

УУРЫН БА ХАЛААЛТЫН ЗУУХ, ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
 АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА

Баталгаажуулалт:

Заавар	Албан тусгаал, овог нэр	Гарын үсэг	Огноо
Хянасан:	Д.Шижирбат /Үйлдвэр хариуцсан менежер/		2021.04.02
Боловсруулсан:	Г.Пүрэвсүх /Ахлах инженер/		2021.04.02

УУРЫН БА ХАЛААЛТЫН ЗУУХ, ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
 АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА
 2021/04/02-Хувилбар 1



C2 (дотоод хэрэгцээнд)

АГУУЛГА

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ	4
1.1. Зорилго	4
1.2. Хамрах хүрээ	4
1.3. Норматив иш таталт	4
2. ҮҮРЭГ ХАРИУЦЛАГА	4
3. АРГАЧЛАЛ	4-5
4. СУРГАЛТ	5

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2022**

УУРЫН БА ХАЛААЛТЫН ЗУУХ, ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА
2021/04/02-Хувицбар 1



C2 (дотоод хэрэгцээнд)

НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

Уурын ба халаалтын зуух, нүүрсхүчлийн хийн үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад үүсэх аюул эрсдлээс урьдчилан сэргийлэхэд оршино.

1.2 Хамрах хүрээ

Энэхүү заавар нь Агар Энержи ХХК-н үйлдвэрийн ажиллагчдад хамаарна.

1.3 Норматив иш таталт

- 1792 - EBU500 нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн ашиглалт засварын заавар
- AISBL ЕВРОПЫН ХИЙН ҮЙЛДВЭРЛЭЛИЙН АССОЦИАЦИ
- DRH-400PG уурын зуухны ашиглалтын заавар
- HGTL-630AP халаалтын зуухны ашиглалтын заавар
- ШНХий алдагдсан тохиолдолд авах арга хэмжээ

2. Үүрэг хариуцлага

Нийт үйлдвэрийн ажиллагчид

Уурын ба халаалтын зуух, шингэрүүлсэн нефтийн хий, нүүрсхүчлийн хийн үйлдвэрийн хөдөлмөрийн аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцан, дагаж мөрдөнө.

3. Заавар

3.1 Уурын зуухны аюулгүй байдал

DRH-400PG уурын зуух нь шингэрүүлсэн нефтийн хийгээр ажилладаг шулуун урсгалт зуух юм. Зуухыг ажиллуулах техникийн ажиллагчид нь энэ чиглэлээр суралцсан, тухайн зууханд зориулсан сургалтанд хамрагдсан байна.

Уурын зуухны ашиглалтын хүмүүс үйлдвэрлэгчээс өгсөн зааврыг сайтар уншиж ойлгосон байх шаардлагатай ба аюулгүй ажиллагаатай холбоотой арга хэмжээнүүдийг мэддэг байх шаардлагатай.

Зуухыг аюулгүй, зөв ажиллуулахын тулд үйлдвэрлэгчийн зааварт заасны дагуу үзлэг, хяналт шалгалтыг тогтмол хийж байх хэрэгтэй. Мөн гэнэтийн аваари, осол гэмтлээс сэргийлж зааварт заасан сэрэмжлүүлийг заавал дагаж мөрдөнө.

Засварын болон үзлэг шалгалтанд буруу багаж хэрэгсэл, зориулалтын бус эд ангийг ашиглахыг хориглоно, мөн засвар болон үзлэг шалгалтын тэмдэглэлийг хадгална.

3.2 Халаалтын зуухны аюулгүй байдал

Халаалтын зуух нь НИППОН ТЕРМОЭНЕР ХХК-ийн зүгээс урт хугацааны туршлага, ололт амжилт дээр үндэслэн гаргасан өндөр үзүүлэлттэй халаалтын зуух юм. Ус халаачийн өдөр тутмын засвар үйлчилгээ, арчилгаа нь түүний ашиглалтын зардал болон ашиглах хугацаанд ихээхэн нөлөөлдөг. Түүнчлэн, энэхүү халаалтын зуухтай буруу харьцах тохиолдолд осол аваарь гарах, ингэснээр хэрэглэгчдэд гэмтэл учруулах эрсдэлтэй. Халаалтын зуухтай ажиллаж эхлэхийн өмнө энэхүү заавартай сайтар танилцаж, бүрэн ойлголттой болох шаардлагатай

4/9#

УУРЫН БА ХАЛААЛТЫН ЗУУХ, ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА
2021/04/02-Хувицбар 1



C2 (дотоод хэрэгцээнд)

Ашиглалтын заавар болон бүтээгдэхүүн дээр дурдагдсан зүйлс нь гарч болох бүх аюул, эрсдэлийг нэг бүрчлэн хамрах боломжгүй юм. Бүтээгдэхүүнтэй харьцахдаа энэхүү гарын авлагад заагдсан зааварчилгаанаас гадна тухайн нөхцөл байдалд тааруулж хамгаалалтын болон аюулгүй байдлын арга хэмжээ авах шаардлагатай.

Зуухны нэрийн пайз дээр заагдсанаас өөр төрлийн түлш хэрэглэж болохгүй. Өөр түлш хэрэглэх нь дутуу шаталт үүсгэх, гал түймэр эсвэл дэлбэрэлтэнд хүргэх аюултай. Хэрэв түлшний хий алдагдаж буй шинж илэрвэл ажиллагааг нэн даруй зогсоож, түлшний хавхлагийг хаагаад, шалтгааныг тогтоон арилгах арга хэмжээ авна. Түлшний хий галдагдах нь гал түймэр гаргах эрсдэлтэй.

Зуухыг ажиллуулж эхлүүлэхийн өмнө агаар өгөлт болон утааны хийн гаралт хангалттай байгаа эсэхийг шалгана. Дутуу шаталтаас болж гал гарах, дэлбэрэх аюултай.

Анхаарах асуудлууд

Уурын ба халаалтын зуухны зааланд ашиглалтын операторууд, үйлдвэрийн менежер, ахлах инженер, химичээс өөр хүмүүс нэвтрэхийг хориглоно.

Зуухны заалны аюултай зүйлүүд, тэмдэглэлүүд, ажлын дараалал гэх мэт аюулгүй байдлын зарчмуудыг хатуу чанд дагаж мөрдөнө.

Зуухан зааланд тамхи татах, ямар нэгэн гал гарах эс үүсвэр болох зүйл байлгахыг хатуу хориглоно.

Бүрэлдэхүүн эд ангид амархан наалдах боломжтой бохир хувцас, эд хэрэглэл зүүх, өмсөхийг хориглоно.

Шатны барилуул болон гишүүр нь тос, шавар гэх зэргээр бохирдсон бол нэн даруй цэвэрлэнэ.

Зуухны өндөр температуртай хэсгийн ойролцоо явж болохгүй /утааны хийн хоолой, үлээлгийн шугам гэх мэт/, эс бөгөөс ноцтой түлэгдэх аюултай.

Зуухны заалан дотор ямар нэг эд зүйлс хатааж болохгүй. Амархан шатдаг зүйлс буюу бензин эсвэл будаг зэргийг зуухны ойролцоо байрлуулж болохгүй. Ийм зүйлс нь гал гаргах эрсдэлтэй.

Утаа гадагшлуулах хоолойн холбоос суларсан, бөглөрсөн эсвэл муудсан бол утааны хийн алдалтын улмаас утааны хийгээр хордох эсвэл дутуу шаталт үүсэх эрсдэлтэй. Сэлгэн залгуурууд эсвэл зуухны бусад эд ангиудад нойтон гараар хүрч болохгүй. Учир нь цахилгаан гүйдэлд нэрвэгдэх аюултай.

Хэрэв дулаан солилцуурын залгаасны хэсэг, хоолойн залгаасны хэсэг эсвэл эргэлтийн насосоос ус нэвчиж алдаж байвал нэн даруй ажиллагааг зогсооно. Ус алдсанаар цахилгаан гүйдэлд нэрвэгдэх, богино холбоо үүсэх эсвэл ажлын доголдол гарах эрсдэлтэй.

Асаагуурыг зөвхөн мэргэжлийн хүнээр буюу зуухаар мэргэшсэн техникч, мөн зуухтай ажиллах сургалтанд хамрагдсан хүмүүсээр л задлуулвал зохино. Буруу ажиллагаанаас болж гал гарах, дэлбэрэлт үүсэх эсвэл гэмтэж бэртэх аюултай.

Хэрэв хэвийн бус дуу чимээ эсвэл үнэр гарч эхлэвэл, ажиллагааг нэн яаралтай зогсооно. Гал гарах, тэсэрч дэлбэрэх эсвэл гэмтэж бэртэх аюултай.

Хэрэв утааны хийн гаралт дээр хар утаа гарч байвал зуухыг нэн даруй зогсоогоод шалтгааныг тогтооно. Шаталтын улмаас гал гарах аюултай.

5/9#

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2022**

УУРЫН БА ХАЛААЛТЫН ЗУУХ, ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА
2021/04/02-Хувиар 1



С2 (дотоод хэрэглэнд)

Зөвхөн тохирсон хүчин чадалтай гал хамгаалагч ашиглана. Мөн өөрийн зориулалтын эд ангийг ашиглана. Учир нь бусад зориулалтын бус эд анги ашигласан тохиолдолд цахилгаан гүйдэлд нэрвэгдэх, гал гарах эсвэл буруу ажиллах эрсдэлтэй.

Аваар осол, гал түймрээс сэргийлэх

Гал түймэр, дэлбэрэлтээс сэргийлэх заавартай танилцаж, галын хор багаж хэрэгслийг ашиглах аргатай нь танилцана.

Галын хор, гал унтраах хэрэгслүүдийг түргэн хүрч болох тодорхой хэсгүүдэд байрлуулна.

Яаралтай тусламжийн хайрцгийг тодорхой газруудад байрлуулна.

3.3 Шингэрүүлсэн нефтийн хийн тоног төхөөрөмж

Уурын ба ус халаах зуухны үндсэн түлш нь шингэрүүлсэн нефтийн хий буюу Бутан хий байна.

Уурын бойлер, халаалтын зуухны ашиглалтын үед гарч болох томоохон ослын гол шалтгаан нь ШНХий алдагдах явдал юм. Иймд хий алдагдсан тохиолдолд дараахь арга хэмжээг авч ажиллана.

Шингэрүүлсэн нефтийн хий алдагдахад

- Хий алдсан газрыг тодорхойлж, түүний ойролцоох хаалтыг хаахаас гадна онц байдлын багаж, шугам хоолойн хий алдалтыг түр зогсоох зориулалтын ороолтын лент ашиглан хий алдалтын хүрээг өргөжүүлэхгүй байх талаар урьдчилан сэргийлнэ.
- Насос, компрессорын ажиллагааг зогсоож, аваарийн клапан, хий нөөцлөх савны доод клапанг хаана.
- ШНХий шингэн болон хий байдлаар их хэмжээгээр алдагдаж байгаа тохиолдолд М Си Эс интернейшл ХХК-ийн аюулгүй байдлын алба, техникийн албаны ажилтнууд, “ЮниГаз” ХХК-ийн аюулгүй ажиллагаа хариуцсан ажилтан, техникийн албаны ерөнхий менежер нарт нэн даруй мэдэгдэнэ. Тухайн осол, осолд дөхсөн тохиолдлыг илрүүлсэн техникийн ажилтан тухайн нөхцөл байдалд зохицсон шийдвэрийг гаргаж, холбогдох байгууллага (гал түймэртэй тэмцэх газар, цагдаагийн газар гэх мэт) тухайн бүс нутгийн гамшигаас хамгаалах байгуулагад мэдэгдэж тусламж хүснэ.
- Тоног төхөөрөмжийн ажиллагааг зогсоох талаар М Си ЭС интернейшл ХХК-ийн холбогдох ажилтнуудад урьдчилан мэдэгдэж тоног төхөөрөмжийг түр хугацаагаар ажиллуулахыг хориглоно.
- Шингэн болон хий байдлаар шингэрүүлсэн нефтийн хий алдалт их байгаа тохиолдолд ус шуршж, хийг сийрэгжүүлж гал авалцахаас урьдчилан сэргийлнэ.
- Хий нь шингэн байдлаар алдагдсан тохиолдолд шороо ба элсээр дүүргэсэн уут болон бусад урсахаас урьдчилан сэргийлэх арга хэмжээ авна.
- Их хэмжээгээр хий алдагдсан тохиолдолд ойр орчмын оршин суугчдад мэдээлж, гал хэрэглэхгүй байхыг хүсэхийн зэрэгцээ ойр орчмын замын хөдөлгөөнийг хаана. Мөн нөхцөл байдлаас хамаарч ойролцоох оршин суугчдыг орогнох газар руу хүргэнэ.

6/9#

УУРЫН БА ХАЛААЛТЫН ЗУУХ, ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА
2021/04/02-Хувиар 1



С2 (дотоод хэрэглэнд)

- Шингэрүүлсэн нефтийн хий шингэн болон хий байдлаар алдагдсан тохиолдолд зөвхөн “ЮниГаз” ХХК-ийн инженер, техникийн баг засварын ажлыг гүйцэтгэх ба бүрэн засварлаж дууссаны дараа тоног төхөөрөмж ажлуулах зөвшөөрөл олгоно.

Ууршуулагчийн өрөөнд хий алдагдахад авах арга хэмжээ

Шингэн фазын холбогч салснаас шингэн алдагдсан тохиолдолд

- Өндөр даралтын хоолой зэргийн доод хаалтыг хаана.
- Гал гаргахыг хориглох ба тухайн орчныг хараандаа авч, хамгаална.
- Холбогч болон тээглүүр нь элэгдэж хуучирсан тохиолдолд шинээр солино.
- Хэвийн байдалтай болгон сэргээн засч, дахин шалгаж ажиллах зөвшөөрөл олгоно.

Хийн фазын холбогч салсны улмаас хий алдагдсан тохиолдолд

- Өндөр даралтын хоолой зэргийн доод хаалтыг хаана.
- Гал гаргахыг хориглоно гэсэн зааврын дагуу орчныг хараандаа авч хамгаална.
- Хэвийн байдалтай болгон сэргээн засч, дахин шалгаж ажиллах зөвшөөрөл олгоно.

Ууршуулагчид гэмтэл гарч хий алдагдсан тохиолдолд

- Ууршуулагчийн өндөр даралтын хаалтыг хаана.
- Шингэн орох хэсгийн ойролцоох шугамын хаалтыг хаана.
- Ууршуулагч доторхи даралтыг бүрэн гадагшлуулан зайлуулна. Хийг гадагшлуулахдаа зориулалтын уян хоолойгоор гадагш аюулгүй зайд сунган орчныг бүрэн хамгаалалтанд авсны дараа аажмаар гадагшлуулана.
- Узелийн байр дотор салхижуулж агаарын солилцоог сайн хийнэ.
- Гал гаргахыг хориглоно гэсэн зааврын дагуу орчныг хараандаа авч хамгаална.
- Тоног төхөөрөмжийг задалж шалгах мөн засвар хийнэ.
- Хэвийн байдалтай болгон сэргээн засч, дахин шалгаж ажиллах зөвшөөрөл олгоно.

Хийн хоолой холболтын хэсэг дээрхи хий алдагдсан тохиолдолд

- Ажлыг нэн даруй зогсооно.
- Хийн хоолойн урд хойд хаалтуудыг хаана.
- Шаардлагатай тохиолдолд савны доод талын хаалтыг хаана.
- Хоолой доторхи даралтыг бүрэн гадагшлуулан зайлуулна.
- Ил гал гаргахыг хориглоно гэсэн зааврын дагуу орчныг хараандаа авч хамгаална.
- Тоног төхөөрөмжийг задалж шалгана.
- Битүүмжлэлийн шалгалтыг хийнэ.
- Шалтгааныг илрүүлж эвдрэлийг засна.
- Хэвийн байдалтай болгон сэргээн засч, дахин шалгаж ажиллах зөвшөөрөл олгоно.

3.4 Нүүрсхүчлийн хийн аюулгүй байдал

Байгаль дээр CO2 нь хий байдалтай байдаг. Энэ хий нь өнгөгүй, үнэргүй, амтгүй тул илрүүлэхэд хэцүү байдаг ч агаар дахь их хэмжээний концентраци нь хамар, нүд, амны хөндийд бага зэрэг мэдрэмж төрүүлдэг. Бүх ажилчдын байнга өртөж болох хязгаар болох босго хязгаарын утга (T.L.V.) нь 5000 ppm буюу 0.5% байна. Өндөр концентрациар амьсгалсан тохиолдолд амьсгал боогдох аюултай. Агаар дахь 10% CO2-ийг хүн хэдхэн минутын турш л тэсвэрлэх боломжтой.

7/9#

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны 2022 менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

УУРЫН БА ХАЛААЛТЫН ЗУУХ, ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА
2021/04/02-Хувилбар 1



C2 (дотоод хэрэглээнд)

Нүүрсхүчлийн хий нь агаараас 1,5 дахин хүнд байдаг. Энэ нь газар дээр, нүх, суваг дээр цугларч, агаарыг нь гартал тэндээ үлдэнэ. CO2 нь жингээрээ агаарыг зайлуулдаг учир амьсгаа боогдох аюултай тул контейнэр зэрэгт орохоосоо өмнө болгоомжлох арга хэмжээг сайн авах хэрэгтэй.

Хадгалах савны температураас үл хамааран цилиндрт хадгалахдаа шингэн CO2 агаар мандалд үлдэх үед -78,5° C-ийн температуртай цас болж хувирдаг бөгөөд арьсанд хүрвэл хурц хөлдөлт үүсгэдэг.

CO2-ийн аюулгүй байдлын талаархи зарим мэдээллийг доор харуулав.

Амьсгалах

Агаар дахь илүүдэл CO2 нь амьсгалын түвшинг дараах хүснэгтэд үзүүлсэний дагуу нэмэгдүүлдэг. Үүнд:

Агаар дахь нүүрсхүчлийн хийн [Эзэлхүүн %]	Уушгины агаар
0.1-1.0	Үл мэдэгдэхүйц өсөлт
2.0	50%-ийн өсөлт
3.0	100%-ийн өсөлт
5.0	300%-ийн өсөлт өгч амьсгалахад хүндэрч эхэлнэ.
10.0	Богино хугацаанд үхэлд хүргэх

Шинж тэмдэг

Эхэндээ импульсийн түвшин нэмэгдэж, агааржуулалтын түвшин нэмэгдэх магадлалтай. Дараа нь амьсгал боогдох үед булчин зангирах, буруу шүүмжлэл өгөх, сэтгэл хөдлөл тогтворгүй байх, ядрах, ухаан алдах, бөөлжих, амьсгаадах, ухаан алдах зэрэг шинж тэмдгүүд илэрдэг.

Урьдчилан сэргийлэх арга хэмжээ

Хувь хүнд учирч болзошгүй хохирлыг багасгахын тулд хохирогчийг нэн даруй агааржуулалт сайтай газарт аваачина. Амьсгалын замд ямар нэгэн саад тогтогч учруулахгүй байхыг анхаарна уу. Цэвэр хүчилтөрөгчөөр хангах хэрэгтэй. Хэрэв амьсгал суларсан эсвэл зогссон бол хүчилтөрөгчийн аппарат ашиглахын зэрэгцээ хиймэл амьсгал хий. Яаралтай түргэн тусламж дуудаж, хохирогчийг дулаацуулж, тайван байлгаарай.

Үйлдвэрийн аюулгүй байдал

CO2 үйлдвэрийг ажиллуулах, үйлчилгээ үзүүлэхдээ аюулгүй байдлын урьдчилан сэргийлэх арга хэмжээг үргэлж дагаж мөрдөх ёстой. Тиймээс үйлдвэрт зөвхөн эрх бүхий ажилтнуудыг ажиллуулахыг зөвшөөрөх хэрэгтэй.

Тоног төхөөрөмжийн ашиглалтын явцад эргэлдэгч тоног төхөөрөмж эхэлж, автомат хавхлагууд мэдэгдэлгүйгээр нээгдэж хаагдаж болохыг анхаарна уу.

Жишээ нь бамбай холболт ба V бүсийг ашиглалтын үед байнга угсарсан байх ёстой. Хэрэв засварын ажлын улмаас тоног төхөөрөмжийг зогсоосон бол санамсаргүйгээр асаахаас урьдчилан сэргийлэхийн тулд цахилгаан холболтыг салгаж, түгжсэн байх

8/9#

УУРЫН БА ХАЛААЛТЫН ЗУУХ, ХИЙН ҮЙЛДВЭРИЙН
АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАРЧИЛГАА
2021/04/02-Хувилбар 1



C2 (дотоод хэрэглээнд)

ёстой. Тоног төхөөрөмжийг асаахгүй байхыг бусад операторуудад анхааруулахын тулд тэмдэг тавих хэрэгтэй.

Засвар үйлчилгээ хийхээс өмнө шугам хоолой болон савны даралтыг гаргасан байх шаардлагатай.

Ямарваа шүүрэлт илэрсэн тохиолдолд түүнийг зассан байх шаардлагатай.

Химийн бодисуудыг зориулалтын дагуу хадгалж, ашиглах шаардлагатай.

Хувийн хамгаалалт

Үйлдвэрт ажиллаж байхдаа хамгаалалтын малгай, хамгаалалтын нүдний шил зүүж байх ёстой бөгөөд хөлдөх, халуун түлэгдэх эрсдэлтэй үед хамгаалалтын бээлий хэрэглэх хэрэгтэй. Энэ нь хязгаарлагдмал орон зайд ажиллахад онцгой ач холбогдолтой юм.

Аваарийн товчлуурууд

Үйлдвэрийг бүхэлд нь зогсоох аваарийн товчлууруудыг (Түгшүүрийн дохио унтраах жагсаалт ба шалтгааны нөлөөллийн бүдүүвчийн дагуу) үйлдвэрт оператор хамгийн хурдан хүрч идэвхжүүлэх боломжтой газарт байрлуулж болно. Оператор аваарийн товчлуурын байрлалуудыг сайтар мэдэж байх ёстой. Хэрэв аваарийн товчлуурыг идэвхжүүлсэн бол үйлдвэрийг буцаан ажиллуулахдаа “Үйлдвэрийг асаах ба зогсоох” хэсэгт заасны дагуу дахин эхлүүлэх шаардлагатай.

9/9#

Зураг 3.1 “Уурын ба халаалтын зуур, хийн үйлдвэрийн аюулгүй ажиллагаа”-ны зааварчилгаа



Зураг 3.2. Химийн бодисын сургалтын гэрчилгээ.



Зураг 3.3. Химийн бодис асгарах үед авах арга хэмжээний сургалт хийгдэж буй байдал

ID	Start time	Email	Сургалт	Овог нэр	Сургалтанд хамрагдсан огноо
12	9/5/22 15:24:37	agaroperator@mcsi.mn	Химийн бодис асгарах үед авах арга хэмжээ	Bileg-Ochir	9/6/2022
13	9/6/22 15:24:37	agaroperator@mcsi.mn	Химийн бодис асгарах үед авах арга хэмжээ	Э. Ганпүрэв	9/6/2022

ID	Completion time	Email	Овог нэр	Сургалтанд хамрагдсан огноо	Сургалт
1	4/20/22 9:18:41	narmandakh.ch@mcsi.mn	Чимэддорц Нармандах	4/19/2022	
2	4/20/22 10:07:33	agaroperator@mcsi.mn	Б.Дэмбэрэлсайхан	4/19/2022	
3	4/21/22 8:37:06	Batmunkh.Bat@mcsi.mn	Б. Батмөнх	4/21/2022	
4	4/21/22 17:17:36	agaroperator@mcsi.mn	С. Тэнгэр	4/21/2022	
5	4/21/22 17:19:24	agaroperator@mcsi.mn	Э. Цэндбаяр	4/21/2022	
6	4/22/22 9:47:23	agaroperator@mcsi.mn	Т.Тэмүүлэн	4/22/2022	
7	4/22/22 14:16:40	agaroperator@mcsi.mn	Г.Мөнх-Эрдэнэ	4/20/2022	
8	4/22/22 23:45:36	agaroperator@mcsi.mn	О.Билэг-Очир	4/22/2022	
9	4/26/22 13:36:02	agaroperator@mcsi.mn	Давхраа ганширэм	4/2/2022	
10	7/6/22 13:05:35	agaroperator@mcsi.mn	Ү. Болдбаатар	7/6/2022	Шинэ ажилтан
11	9/30/22 11:05:34	agaroperator@mcsi.mn	Э.Ганпүрэв	9/30/2022	Шинэ ажилтан

Зураг 3.4. Химийн бодисын сургалтанд суусан ажиллагсдын бүртгэл

ХИМИЙН БОДИСЫГ ҮЙЛДВЭРТ АШИГЛАХ АЮУЛГҮЙ АЖИЛЛАГААНЫ ЗААВАР

Химийн бодисын өрөөнөөс уурын зуухны аж ахуйд химийн бодисыг зөөхдөө ашиглалтын операторууд дараах зааварчилгааг дагана:

Коагулянт-К бодисыг ашиглах:



1.

Химийн бодисын өрөөний агааржуулалтыг шалгаж нээнэ.




2.

Химийн бодисын өрөөнд байршуулсан Коагулянт-К бодисын аюулгүй ажиллагааны зааварчилгаатай танилцана. Үүнд: Химийн бодис бүрийн аюулгүй ажиллагааны заавар, хор аюулын лавлах мэдээлэл (ХАЛМ)



3.

Химийн бодисоос хамгаалах нэг бүрийн хамгаалах хэрэгслийг бүрэн өмсөж хэвшинэ



4.

Бодис зөөх улаан шугам, тэмдэглэгээний дагуу бодисыг зөөнө.





5.

Заавал бодис дозлогчын дэргэд химийн бодисын савны лацыг авна.

Уурын зуухны бодис дозлогчын савны тагыг нээн бодисыг юүлнэ.




6.



Хоосон химийн бодисын саван дээр аюултай хог хаягдал гэсэн бичиг нааж аюултай хог хаягдлыг контейнерт хийж, химийн хорт бодисын хаягдал боловсруулах компанид хүлээлгэн өгнө.

Зураг 3.5.Химийн бодисын хадгалалт, тээвэрлэлт, ашиглалт, устгалд хяналт тавих үйл ажиллагааны дотоод заавар

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2022**


“АГАР ЭНЕРЖИ” ХХК-Д

НИЙСЛЭЛИЙН ЗАСАГ ДАРГЫН ХЭРЭГЖҮҮЛЭГЧ АГЕНТЛАГ
МЭРГЭЖЛИЙН ХЯНАЛТЫН ГАЗАР
УЛСЫН БАЙЦААГЧИЙН ДҮГНЭЛТ
 Нийслэлийн засаг захиргааны III байр,
 Ж.Самбуугийн гудамж, 4 дүгээр хороо,
 Чингэлтэй дүүрэг, Улаанбаатар хот, 15170
 Утас: 7777-5000, Факс: 7777-5120
 E-mail: ub_info@inspection.gov.mn
 http://www.ub.inspection.gov.mn

2021.03.04 № 02-04-090/130
 таяг _____ -ны № _____ -г

Г Химийн бодисын агуулахын тухай Г

Тус газарт ирүүлсэн Баянзүрх дүүргийн 10 дугаар хороо, Гачууртын зам “М Си Эс Коко Кола” ХХК-ийн үйлдвэрийн хашванд орших агуулахад химийн бодис хадгалах дүгнэлт гаргуулах хүсэлтээр МХЕГ-ын даргын баталсан “Баталгаажуулалтын хяналт шалгалт хийх тухай” 01/13 тоот удирдамжийн дагуу 2021 оны 02 дугаар сарын 25-ны өдөр хяналт шалгалт хийлээ.

“Агар энержи” ХХК нь аж ахуйн нэгжийн улсын бүртгэлийн 9011391089 тоот гэрчилгээтэй, 6423701 тоот регистрийн дугаартай.

Тус компани нь хүнсний зориулалттай шингэрүүлсэн нүүрсхүчлийн хийг шинэчлэхэд ашиглагдах 27 нэр төрлийн урвалж бодис, зуухны ажиллагаанд ашиглагдах 7 нэр төрлийн бодисонд “Ашиглах” зөвшөөрөл авахаар Грийнхимистри ХХК-тай гэрээ байгуулсан, тухайн бодисуудын хор аюулын лавлах мэдээллийн хуудастай.

Химийн бодис хадгалах өрөө нь 36,1 м² талбайтай, механик агааржуулалтын системтэй, дулаан, цэвэр, бохир ус нь төвийн нэгдсэн шугаманд холбогдсон, харуул хамгаалалттай.

Химийн бодис хадгалах өрөөнд хийсэн физик хэмжилтээр гэрэлтүүлэг 300 люкс байна.

Хяналт шалгалтаар 2.11 хяналтын хуудсаар эрсдэлийг үнэлэхэд 26% буюу бага эрсдэлтэй үнэлэгдсэн.

Ажилтанд аюулгүй ажиллагааны нэг бүрийн хамгаалах хэрэгсэл, ажлын хувцас олгож, болзошгүй ослын үед ажиллах бэлэн байдлын төлөвлөгөөг боловсруулж батлуулсан байна.

Дээрх байдлыг үндэслэн дүгнэлт болгох нь:
 “Агар энержи” ХХК-ийн химийн бодис хадгалах агуулах нь “Химийн хорт болон

Хөдөлмөрийн эрүүл ахуй, Химийн хорт болон бодисын бүтээгдэхүүний ерөнхий шаардлага MNS 6458:2014 стандарт, Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй. Ажлын байран дахь гэрэлтүүлгийн хэмжилт, зөвшөөрөх хэмжээнд тавих ерөнхий шаардлага MNS 6767:2019 стандартын шаардлагыг хангаж байна.

Хэрэв хяналт шалгалтын дүн болон улсын байцаагчийн гаргасан шийдвэрийг үндэслэлгүй гэж үзвэл Төрийн хяналт шалгалтын тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 1 дэх хэсэгт заасны дагуу гомдол гаргах эрхтэй болно.

Хэмжилтийг тухайн өдрийн байдлаар тодорхойлов.

БАЙГАЛЬ ОРЧНЫ ХЯНАЛТЫН
 УЛСЫН АХЛАХ БАЙЦААГЧ


 Г.УДВАЛ

ХӨДӨЛМӨРИЙН ЭРҮҮЛ АХУЙН
 ХЯНАЛТЫН УЛСЫН БАЙЦААГЧ



 О.АЛТАНТУЯА

ХҮЛЭЭН АВСАН:
 МЕНЕЖЕР


 Б.САРУУЛ


Тайлбар: *Эн ай Маргуй.*

Зураг 3.6. Химийн бодисын агуулахын дүгнэлт



Зураг 3.7. Химийн бодисын ослын үед авах арга хэмжээний төлөвлөгөө

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2022**



Зураг 3.8. Химийн бодисын агуулах

Батлав: Үйлдвэр хариуцсан менежер  Д.Шижирбат

ХИМИЙН БОДИС ХҮЛЭЭН АВАХ ҮЕИЙН ХЯНАЛТ			
Баримт бичгийн дугаар	АЕ-1504-REC008-211221v2	Хамрах хүрээ	Агар Энержи ХХК
Боловсруулсан огноо	2020.12.21	Хариуцагч	Химич
Шинэчилсэн огноо	-	Хадгалалт	Химийн лабораторид
Батлуулсан огноо	-	Орсон өөрчлөлт	-
Хуучинтай хугацаа	Шинэчлэгдэн батлагдах хүртэл	Хянасан	-
Хувилбар	2	Боловсруулсан:	1/ Д.Шижирбат үйлдвэрийн менежер 1/ Б.Баярсүхийг химич

№	Хүлээж авсан огноо	Монгол нэр	Олон улсын нэр	Томьёо	Химик нэгж	Төг хэмжээ	Зориулалт	Чарангарчиглаа	ХАЛМ	Шонго	Сав баглаа	Тээвэрлэлт		Шавьж, мэргэжч байгаа эсэх	Үйлдвэрлэсэн хугацаа	Дуусах хугацаа	Хүлээлгэн өгсөн хүний гарын үсэг	Хүлээж авсан хүний гарын үсэг	Дугаар
												мөчөл	нээгдсэн						
1	21.12.21	Моностава амин	MEA	$C_2H_5NH_2$	кг	840	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	№	21.01.08	22.07.06	Ариунзүрх	Баярцаа	MEA 2107201
2	22.02.08	Сога	Карбоний карбонат	Na_2CO_3	кг	1400	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021.09.19	23.03.19	Ариунзүрх	Баярцаа	Soda 2202021
3	22.02.11	Carbo Blend	Carbo Blend	-	кг	50	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021	2024	Ариунзүрх	Баярцаа	Soda 220202
4	22.02.18	Моностава амин	MEA	$C_2H_5NH_2$	кг	630	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021.01.08	22.07.06	Ариунзүрх	Баярцаа	MEA 2202021
5	22.02.26	Carbo Blend	Carbo Blend	Na_2CO_3	кг	3000	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021	2024	Ариунзүрх	Баярцаа	Soda 2202021
6	22.03.09	Сога	Карбоний карбонат	Na_2CO_3	кг	400	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021.09.19	23.03.19	Ариунзүрх	Баярцаа	Soda 2203021
7	22.03.09	MEA	MEA	$C_2H_5NH_2$	кг	420	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021.01.08	22.07.06	Ариунзүрх	Баярцаа	MEA 220301
8	22.05.08	MEA	MEA	$C_2H_5NH_2$	кг	210	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021.09.19	22.09.02	Климентий	Б.Баярцаа	MEA 220501
9	22.05.16	Сога	Карбоний карбонат	Na_2CO_3	кг	800	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021.09.19	2023.02.19	Климентий	Б.Баярцаа	Soda 220501
10	22.05.17	MEA	MEA	$C_2H_5NH_2$	кг	210	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021.09.19	22.09.02	Климентий	Б.Баярцаа	MEA 220502
11	22.05.20	MEA	MEA	$C_2H_5NH_2$	кг	420	CO_2 -үйлгэгч	✓	✓	✓	✓	OK	OK	Үгүй	2021.09.19	22.09.02	Климентий	Б.Баярцаа	MEA 220503

*- Химийн бодисын анхваруулах, аюулын тухай санамжийг байршуулсан зориулалтын тээврийн хэрэгсэлээр тээвэрлэдэг /Химийн хорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам 4.1.2 дэх заалт/

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан 2022

ХИМИЙН БОДИС ХҮЛЭЭН АВАХ ҮЕИЙН ХЯНАЛТ
Тайлбар: Химич химийн бодис, материал хүлээн авах үед доорхи хуудсаар бүртгэж хүлээж авна /Журнал болон, битүүмжлэл/

№	Хүлээж авсан огноо	Монгол нэр	Олон улсын нэр	Томьёо	Химийн нэр	Төр хэмжээ	Зориулалт	Чанарын гарчигтга	ХАЛМ	Шашго	Сав баглаа	Тээвэрлэлт		Шавьж, мэрэгч байгаа эсэх	Үйлдвэрлэсэн хугацаа	Дуусах хугацаа	Хүлээлгэн өгсөн хуний гарын үсэг	Хүлээж авсан хуний гарын үсэг	Дугаар
												нөхцөл	тээврийн хэрэгсэл						
1	2021.06.09	Моноэтаноламин	MEA	C ₂ H ₅ NH ₂	К	420	CO ₂ үйлдвэр	✓	✓	✓	✓	✓	✓	✓	2021.09.03	22.09.03	Хөмөр	Баянзүрх	МЭА 220607
2	2022.09.04	Ковалит-К	Ковалит-К	mixed	К	240	Уурын зуух	✓	✓	✓	✓	✓	✓	✓			Хөмөр	Баянзүрх	Кос 220607
3	2022.07.07	Моноэтаноламин	MEA	C ₂ H ₅ NH ₂	К	420	CO ₂ үйлдвэр	✓	✓	✓	✓	✓	✓	✓	2021.09.03	22.09.03	Хөмөр	Баянзүрх	МЭА 220607
4	2022.07.07	Изофланин	Combo Blend 12	C	К	175	CO ₂ үйлдвэр	✓	✓	✓	✓	✓	✓	✓	2022	2025	Хөмөр	Баянзүрх	МЭА 220607
5																			
6																			
7																			
8																			
9																			
10																			
11																			
12																			
13																			
14																			

* Химийн бодисын анхваруулах, аюулын тухай санамжийг байршуулсан зориулалтын тээврийн хэрэгсэлээр тээвэрлэдэг /Химийн жорт болон аюултай бодисыг хадгалах, тээвэрлэх, шилжих, устгах журам 4.1.2 дахь зөвлт/

ХИМИЙН БОДИСЫН ОРООНШ ХЯНАЛТ

Баримт бичгийн дугаар	AE-1504-REC010-2020v1	Хамрах хүрээ	Агар Энержи ХХК
Боловруулсан огноо	2020.11.05	Хариуцагч	Химич
Шинэчилсэн огноо	-	Хадгалалт	Химийн лабораторид
Батлуулсан огноо	-	Орсон өөрчлөлт	-
Хүчинтэй хугацаа	-	Боловруулсан	/ Б.Баярцэцэг, химич
Хуудасны тоо	1	Давтамж	7 хоног бүр

№	Монгол нэр	Томьёо	2022.09.16 - 09.25			2022.09.26 - 10.03			2022.10.04 - 2022.10.07		
			Химийн бодис алдагдсан эсэх	Агааржуулалтын системийн ажлалгаа	Тосгуур, сав, суурины нэгдэлт, тавнуурын холбооны бүрэн бүтэн байдал	Химийн бодис алдагдсан эсэх	Агааржуулалтын системийн ажлалгаа	Тосгуур, сав, суурины нэгдэлт, тавнуурын холбооны бүрэн бүтэн байдал	Химийн бодис алдагдсан эсэх	Агааржуулалтын системийн ажлалгаа	Тосгуур, сав, суурины нэгдэлт, тавнуурын холбооны бүрэн бүтэн байдал
Уур усны зууханд хэрэглэх химийн бодис											
1	Ковалит-К	Mixture	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK
Хийн үйлдвэрт хэрэглэх химийн бодисууд											
2	Натрийн карбонат	Na ₂ CO ₃	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK
3	Цископентан Нүүрстөрөгчийн диоксида	C ₅ H ₁₀ CO ₂	-	-	-	-	-	-	-	-	-
4	Моноэтаноламин	N(CH ₂ CH ₂ OH)	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK
5	Натрийн гидроксид	NaOH	-	-	-	-	-	-	-	-	-
6	Полисилаксан MEA хоос даргач	N(CH ₂ CH ₂ OH)	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK
Хийн үйлдвэрийн тоног төхөөрөмжийн тос тослогонны материал											
7	Изаляжүүлсэн нүүрс	C	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK
8	Хөнгөн цагааны оксид	Al ₂ O ₃	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK
9	Kaltemaschinel BSE 170 Тослох материал	mixture	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK
10	Shell Omala S2 GX 150 Эд ангины тослох материал	mixture	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK
11	FORANE 404A Хөргүүрийн шингэн	CF ₃ CHF ₂ C ₂ H ₂ F ₃ CH ₂ FCF ₃	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK	OK

Зураг 3.9. Химийн бодис хүлээн авах үеийн болон агуулахын хяналт

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших
 “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны **2022**
 менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан

ИХМаягт БМ-9

Санхүү, эдийн засгийн сайд, Үндэсний статистикийн газрын даргын
 2002 оны 6-р сарын 18-ний 171/111 тоот тушаалын хавсралт

БАРАА МАТЕРИАЛЫН ТАЙЛАН


Тайлант хугацаа 2022/09/01-2022/09/30 Эд хариуцагчийн нэр Б.Баярцэцэг
 Компанийн нэр Агар Энержи ХХК Агуулахын нэр, ¹ Агар химийн бараа

д/д	Бэлтгэн нийлүүлэгч	Бараа, материалын үнэт зүйлийн нэр, зэрэг, дугаар	Хэмжих нэгж	Тоо хэмжээ					Тайлбар
				Эхний үлдэгдэл	Орлого	Зарлага	Цэцүүх ХХК үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	
1	Цэцүүх ХХК	Натрийн карбонат/техникийн сода	кг	450		90	-	360.0	
2	Цэцүүх ХХК	МЕА хөөс дарагч	кг	8.1	-	-	-	8.1	
3	Цэцүүх ХХК	Идэвхижүүлсэн нүүрс \4мм\	кг	50	-	-	-	50	
4	Цэцүүх ХХК	Идэвхижүүлсэн нүүрс \3.2мм\	кг	125	-	-	-	125	
5	Цэцүүх ХХК	Хөнгөнцагааны исэл	кг	320	-	-	-	320	
6	Цэцүүх ХХК	Моноэтаноламин	кг	320	-	75	3,360	3,605	
7	Цэцүүх ХХК	Натрийн хлорид	кг	2.0	-	0.0375	-	1.96	
8	Цэцүүх ХХК	Аммоны роданид	кг	0.5	-	0.05	-	0.45	
9	Цэцүүх ХХК	Аммоны хлорид	кг	1.0	-	0.02	-	0.98	
10	Цэцүүх ХХК	Этилийн спирт	л	1.5	-	0.05	-	1.45	
11	Цэцүүх ХХК	Давсны хүчил	л	1.0	-	0.3	-	0.70	
12	Цэцүүх ХХК	Аммиак	л	1.0	-	0.088	-	0.91	

Эд хариуцагч

 /Б.Дэлгэрцэцэг /

Зөвшөөрсөн:

 /Д.Шигирбат/

Зураг 3.10. Химийн бодис, материалын сарын тайлан

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2022**

The screenshot shows a web browser window with the URL <https://chemical.met.gov.mn/mn/profile>. The page title is 'Химийн хорт болон аюултай'. The main content area displays a table of chemical substances with the following columns: Цэвэр эсэх, Монгол нэр, Олон улсын нэршил, CAS дугаар, Химийн томъёо, БТКУС код, Хольц бодис, Төлөв, Бодисын гарилгаа, ХАЛМ, and Үйлдэл. The table contains three entries:

Цэвэр эсэх	Монгол нэр	Олон улсын нэршил	CAS дугаар	Химийн томъёо	БТКУС код	Хольц бодис	Төлөв	Бодисын гарилгаа	ХАЛМ	Үйлдэл
1. ✓	Карбонил сульфид	Carbonyl sulphide	463-58-1	CO _S			Илгээсэн			
2. ✓	Нүүрсхүчлийн хий	Carbondioxide	124-38-9	CO ₂			Илгээсэн			
3. ✓	Кобальтийн карбонат	Cobalt carbonate	513-79-1	CoCO ₃			Илгээсэн			

At the bottom of the table, it indicates 'Хуудас 1 of 1' and 'Энэ хуудсанд 1 - 3. Нийт 3'.

The screenshot shows the profile page for 'Агар энержи' on the 'chemical.met.gov.mn' website. The page includes contact information and a table of administrative activities.

Агар энержи
 ХҮР системээс мэдээлэл татах

Код: С-103
 Регистрийн дугаар: 6423701
 Утасны дугаар: 77226262
 Факс: 77226464
 И-мэйл: -

УДИРДАХ АЖИЛТАН

Албан тушаал	Өвөг
Регистр	Нэр

Хариуцсан ажилтан

Албан тушаал	Өөрийн нэр	Эцэг (эх)-н нэр	Утас 1	Утас 2	Цахим хааг	Үйлдэл
1. Химич						
2. Химич						

Зураг 3.11. Жил бүрийн химийн бодисын бүртгэл, зарцуулалтын тайланг яамны нэгдсэн системээр хийхээр болсон ба манайх албан ёсоор системд бүртгүүлсэн. Тайлан гаргах үйл явц нь яамнаас хөгжүүлэлт хийгдэж байгаа.



Коагулянт-К

Анхны туслалж

- Хэрэв хоол боловсруулах замд орсон бүтээгдэхүүнийг биеэс гаргах зорилгоор 3-4 аяга ус ууна.
- Боолжих, бие эвгүйрхэх тохиолдолд эмчид хандана.
- Арьсанд хүрсэн тохиолдолд хүрсэн хэсгийг усаар угаана.
- Нүдэнд орсон тохиолдолд их хэмжээний усаар угаана. Хэрэв цочрол үүссэн бол эмчид хандах хэрэгтэй.

Эрүүд мэндэд хөнөөлтэй

Урьдчилан сэргийлэх мэдээлэл(GHS-US):

- Арьс, нүд, зэвгцхээс зайлсхийх хэрэгтэй.
- Хувийн хамгаалах хэрэгсэл өмсөнө.
- Хүчтэй хүчил, галын эх үүсвэрээс хол байлгана.
- Бүтээгдэхүүний алагдагдсан тохиолдолд их хэмжээний усаар цэвэрлэнэ.
- Амьсгалсан тохиолдолд цэвэр агаарт гаргана. Хэрэв цочрол үүссэн бол эмчид хандах хэрэгтэй.

Моноэтаноламин (МЕА)

АЮУЛТАЙ

Аюулын мэдээлэл(GHS-US):

H312- Амьсгалдад хортой
H312- Арьсанд хурвал хортой
H302- Залгивал хортой
H314- Арьсыг түлэх, нүдийг гэмтгэх аюультай
H335- Нүдийг цочрооно

Урьдчилан сэргийлэх мэдээлэл(GHS-US):

P280- Хамгаалалтын хувцас, нүдний шил, маск, бээлий хэрэглэнэ.
P308+P313- Хэрэв залгивал амьсгалын байгууллагад хандана.
P305+P351+P338- Хэрэв нүдэнд орсон усаар сайтар угаана. Лийн дүүсэн тохиолдолд хурдан авч хана. Үргэлжүүлэн угаана.
P301+P330+P331- Хэрэв залгивал амаа сайтар угаана. Хүчээр боолжих гэж оролдож боолхгүй.
P303+P361+P353- Хэрэв ус, арьсанд хүрвэл сайтар усаар угаана. Бохирдсон хэсгийн хувцасны тийж сайтар угаана.
P337+P313- Нүдийг цочроосон тохиолдолд эмчид хандана

Илэмхий Аюультай

Зураг 3.12. Химийн бодисын агуулахад ашиглаж буй химийн бодисын ХАЛМ болон аюулгүй ажиллагааны зааварчилгааг байрлуулсан байдал

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2022**

ЗААВАР
2021/02/25 – Хувилбар 1



C2 (дотоод хэрэгцээнд)

БАТЛАВ: АГАР ЭНЕРЖИ ХХК,
ҮЙЛДВЭР ХАРИУЦСАН МЕНЕЖЕР: /Д.ШИЖИРБАТ/

Баримт бичгийн төрөл:	Заавар
Үйлчлэх хүрээ:	Агар Энержи ХХК
Хэрэгжүүлэх нэгж, ажиллагчид:	Химийн бодистой харьцаж ажиллагсад
Хэрэгжилтэд хяналт тавих:	Химич
Нууцын зэрэг:	C2 (дотоод хэрэгцээнд)
Хүчинтэй хугацаа:	Хүчингүй болгох хүртэл
Хуудасны тоо:	7
Анх баталсан огноо	2021.02.25

АЮУЛТАЙ МАТЕРИАЛ ГООЖИХ, АСГАРАХ ҮЕД АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ЗААВАР

Баталгаажуулалт:

Журам	Албан тушаал, овог нэр	Гарын үсэг	Огноо
Хянасан:	Д.Шижирбат /Үйлдвэр хариуцсан менежер/		
Боловсруулсан:	Б.Баярцэцэг Б.Дэлгэрцэцэг /Химич/		2021.02.25

ЗААВАР
2021/02/25 – Хувилбар 1



C2 (дотоод хэрэгцээнд)

1. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ

1.1 Зорилго

Үйлдвэрлэлийн үйл ажиллагааны явцад ашиглагдаж буй аюултай материалыг асгарах, алдагдхаас урьчилан сэргийлэх, хянахад оршино.

1.2 Хамрах хүрээ

Энэхүү аргачлал нь аюултай материалтай харьцаж ажиллах бүх ажилчдад хамаарна.

1.3 Норматив иш таталт

Энэхүү шаардлагыг боловсруулахдаа дараах бичиг баримтыг үндэслэл болгов.

Монгол Улсын Хууль “Химийн хорт болон аюултай бодисын тухай”

2009.02.03-ны 28/40/29 дугаар хамтарсан тушаалын 1 дүгээр хавсралт “Химийн хорт болон аюултай бодис хадгалах, тээвэрлэх, ашиглах, устгах журам”

2. Үүрэг хариуцлага

Ашиглалтын оператор:

Аюултай материал гоожих, асгарахаас урьдчилан сэргийлэх аргачлалын дагуу химийн бодисын ашиглалтын үед ХАБЭА-н аюулгүй байдлыг ханган ажиллана.

Химич:

Аюултай материал гоожих, асгарахаас урьдчилан сэргийлэх аргачлалын дагуу химийн бодисын ашиглалтын үед ХАБЭА-н аюулгүй байдлыг хангуулж, хянаж ажиллана.

3. Заавар

Аюултай материалыг гоожих, асгарахаас урьдчилан сэргийлж хянахад дараах элементүүдийг оруулсан байх. Үүнд:

Химийн бодистой харьцаж ажиллах ашиглалтын операторууд гарч болох хүндрэлүүдийн үед авах арга хэмжээ

- Химийн бодис асгарч гоожсон орчныг яаралтай тусгаарлах, хүмүүсийг гаргах, хүн нэвтрүүлэхгүй байх.
- Аюултай, хортой бодис асгарсан үед агааржуулалтын системийг асаах буюу амархан дэгддэг хортой бодис асгарвал орон байрнаас хүмүүсийг зайлуулах, түүнийг бүрэн ууршиж уур нь үгүй болтол байрыг агааржуулах.



“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2022**

ЗААВАР
2021/02/25 – Хувилбар 1



IV. Шингэн бодис асгарсан тохиолдолд, бодис асгарсан тархалтыг зогсоох шингээгч материалаар асгарсан бодисыг хүрээлж дээр нь шингээгч материалыг тавин орчныг цэвэрлэнэ.



V. Дараа нь химийн бодисыг 2% лимоны хүчлийн хор саармагжуулах уусмалаар саармагжуулан, зориулалтын аюултай хаягдлын уутанд хамж хийнэ.

ЗААВАР
2021/02/25 – Хувилбар 1



VI. Хуурай бодис асгарсан тохиолдолд асгарсан бодисын тархалтыг зогсоож, хогын шүүрээр шүүрдэн авч, орчныг цэвэрлэн, зориулалтын хаягдлын уутанд хамж хийнэ.

“Агар Энержи” ХХК-ийн Нийслэлийн Баянзүрх дүүргийн 10-р хорооны нутагт байрших “Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр”-ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлан **2022**

ЗААВАР
2021/02/25 – Хувилбар 1



Зохион байгуулах хүн, шаардлагатай бол гадны мэргэжлийн хүн, байгууллага

- Үйлдвэрийн химич хариуцаж зохион байгуулна
- Шаардлагатай тохиолдолд БЗД-ийн ОБХэлтэст /105 дугаарын утсаар/ мэдэгдэж хамтран арга хэмжээг авна

Бусад газруудад авах арга хэмжээг зохион байгуулах /нүүлгэн шилжүүлэлт, эмнэлгийн тусламж, гал унтраах/

- Аарах бүлэг /хэрэв химийн бодис асгарч гоожсонтой холбоотой гал түймэр гарах, нүүлгэн шилжүүлэх, нэрвэгдсэн хүмүүсийг тухайн орчноос гаргах үед/88105063/
- БЗД-ийн ОБХэлтэс /11325 /26/
- Эмнэлгийн байгууллага / нэрвэгсдэд эмнэлгийн үзүүлэх үед/103/

Мэдээлэх болон зарлах

- Компанийн удирдлагууд
- Орон нутгийн эрх бүхий байгууллагууд

Хяналтын арга хэмжээ

- Хаягдлыг тусгай хэсэгт /химийн бодисын хаягдлын агуулах/ хадгалах
- Эрсдэл гарсны дараа шалтгааныг судалж дүгнэх
- Дүгнэлтийг үндэслэн авах арга хэмжээний зааврыг сайжруулах

4. Сургалт

Аюултай материалтай харьцаж ажилладаг компанийн ажилтан ажиллагсдад энэхүү зааврыг танилцуулж улирал бүр сургалтыг зохион байгуулна.

ЗААВАР
2021/02/25 – Хувилбар 1



- VII. Ажилчдыг тухайн орчноос холдуулж цэвэр агаарт байлгана.
- VIII. Аюултай хог хаягдлын уутыг аюултай хог хаягдал цуглуулах контейнерт хийж, Кока Кола компанийн химийн бодисын няравт хүлээлгэн өгнө.

Зураг 3.13. Аюултай материал гоожих, асгарах үед авах арга хэмжээний заавар



Зураг 3.14. Химийн бодисын асгаралтын иж бүрдэл химийн бодисын агуулахад байршуулсан байдал



Зураг 3.15. Химийн бодисын агуулах болон хийн аж ахуйн зааланд нүд угаах төхөөрөмж болон шүршүүр суурилуулсан байдал.



Зураг 3.16. Үйлдвэрийн гадна байрлах тоноглуудыг оруулан барилга байгууламжинд өргөтгөлийн барилга барьсан байдал.

ХАВСРАЛТ 5. ХОГ, ХАЯГДЛЫН МЕНЕЖМЕНТИЙН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



Тайлбар : Өмнө нь



Тайлбар: Одоо


Зураг 4.1. Ахуйн хог хаягдалыг ангилан хаях хогийн савыг сайжруулсан байдал

ХИМИЙН БОДИСЫН АЮУЛТАЙ ХОГ ХАЯГДАЛ, БҮРТГЭЛ								
№	Монгол нэр	Олон улсын нэр	Томьёо	Савлагал	Савлаганы материал	Хэмжих нэгж	Хаягдал/гуршилт, тохируулга/	
							Хаягдал /04-07сар/	Хаягдал /08-12 сар/
Баримт бичгийн дугаар: АЕ-1504-REC011-2020v1								
Боловсруулсан огноо: 2020.08.05		Хамрах хүрээ: Агар Энержи ХХК		Хариуцагч: Химич		Хяналт: Химийн лабораторид		
Шинэчилсэн огноо: -		Хадгалалт: -		Орсон өөрчлөлт: -		Формыг хянасан: / / Д.Шижирбат үйлдвэрийн менежер		
Батлуулсан огноо: -		Шинэчлэгдэн батлагдах хуртал		Боловсруулсан: / / Б.Баярсүлдэг, химич				
Хүчинтэй хугацаа: -		Хувилбар: 1						
Зууханд хэрэглэх химийн бодис								
1	Коагулянт-К	Коагулянт-К	Mixture	25 кг	Канистр	ш	6 + 3 + 2	5 + 2
Хийн үйлдвэрт хэрэглэх химийн бодисууд								
2	Натрийн карбонат	Sodium carbonate anhydrous	Na ₂ CO ₃	25 кг	шуудай	ш		
3	Моноэтанол амин	Monoethanolamine, 98-100%	N(CH ₂ CH ₂ OH)	200 кг	Почка	ш	10+6+8+16+3	8+5+2
4	Фреон	Freon-404A	CF ₃ CHF ₂ C ₂ H ₃ F ₃ CH ₂ FCF ₃	10.5кг	Төмөр баллон	ш		
Лабораторид ашиглах химийн бодисууд								
5	Хуурай бодисууд	жижиг савлагаа бүхий лабораторийн шинжилгээний бодисууд		0.25 кг	Хуванцар	ш		
6	Шингэн бодисууд			0.25 кг	шилэн	ш		
CO ₂ аж ахуй тоног тохөөрөмжийн тос тосолгооны материал								
7	Илэвхижүүлсэн нүүрс	Carbonblend # 1	C	25 кг	шуудай	ш		
8	Илэвхижүүлсэн нүүрс	Carbonblend # 2	C					
9	Хөнгөн цагааны оксид	Puriblend # 1	Al ₂ O ₃	30 кг	шуудай	ш		
10	Хөнгөн цагааны оксид	Puriblend # 2	Al ₂ O ₃					
11	Kaltemaschinenol BSE 170 Тослох материал	Kaltemaschinenol BSE 170	mixture	10 л	төмөр сав	ш		
12	Shell Omala S2 GX 150 Эд ангийн тослох материал	Shell Omala S2 GX 150	mixture	20 кг	Канистр	ш		
						Нийт	ш	

Зураг 4.2. Аюултай хог хаягдлын бүртгэл



Зураг 4.3 Дахивар хаягдлын цэг



Зураг 4.4 Дахин боловсруулах боломжгүй ахуйн хаягдлын цэг



Зураг 4.5 Аюултай хог хаягдлын түр цэг /Аюултай хог хаягдлын түр цэгт хаягдлыг хаяж буй байдал/

ХАВСРАЛТ 6. УДИРДЛАГА ЗОХИОН БАЙГУУЛАЛТЫН ТӨЛӨВЛӨГӨӨНИЙ БИЕЛЭЛТ



Зураг 5.1. Нийт ажилчдын ХАБЭАБО-ны сургалтанд хамрагдаж буй байдал



Зураг 5.2. Гамшиг осол, гал түймрийн аюулаас урьдчилан сэргийлэх сургалтанд хамрагдаж буй байдал



Зураг 5.3. Газар хөдлөлт, гамшгийн үеийн аврах ажиллагааны сургалтанд хамрагдаж буй байдал



Зураг 5.4. Байгаль орчныг хамгаалах , хог хаягдлын талаар мэдээллийн самбар гаргаж байршуулсан байдал



Зураг 5.6. Үйлдвэрийн хэмжээнд хойд болон зүүн хэсэгт 2 галын сарай /Гал унтраах анхан шатны иж бүрдэл/, гал унтраагуур 28ш, галын гидрант 4ш, автомат гал унтраагуур болон галын дохиололын автомат системд холбогдсон. Сургалтанд ашигласан 4ш галын хорыг баталгаажуулсан байдал.






Зураг 5.7. Өргөтгөлийн барилгад галын дохиолол, утаа мэдрэгч, автомат гал унраагуур суурилуулсан байдал.



Зураг 5.8. Галын аюулгүй ажиллагааны самбарыг нэвтрэх хэсэг болон өргөтгөлийн барилга дотор байршуулсан байдал

ХАВСРАЛТ 7. Тухайн жилийн байгаль орчны менежментийн төлөвлөгөөний хэрэгжилтийг нөлөөллийн бүсэд оршин суугчдад тайлагнах төлөвлөгөөний биелэлт

“Уурын зуух болон нүүрсхүчлийн хийн үйлдвэр” –ийн 2022 оны байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийн тайлантай танилцсан

Овог нэр	Албан тушаал	Утасны дугаар	Гарын үсэг	Огноо
Н. Эрдэнэбилэг	Засаг захирал	9903858		2022.10.25
С. Мөнхсайхан	Нийслэлийн ажилтан	9919205		2022.10.25
Т. Овооручин	6-р хэлмэгч ахлагч	99827560		2022.10.25

Тайланг танилцуулсан: 

/Агар Энержи ХХК-ийн БОХАБ хариуцсан ажилтан Э.Эрдэнэбилэг/

Зураг 6.1 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 10-р хорооны Засаг дарга, төлөөлөгч нарт танилцуулан баталгаажуулсан хуудас



Зураг 6.2 Байгаль орчны менежментийн төлөвлөгөөний биелэлтийг 10-р хорооны Засаг дарга, төлөөлөгч нарт танилцуулан, үйлдвэрийн үйл ажиллагаатай танилцуулж буй байдал